



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
БАЯН-АДАРГА СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 26 өдөр

Дугаар A/41

Баян-Адарга

Г Мал амьтны сэг зэм устгал, орчны 7  
халдваргүйтэлийн арга хэмжээ зохион  
байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1.13 дахь заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, 7.3.1, 7.3.2, 7.3.3, 7.3.4, 7.3.6 дахь заалт, Хэнтий аймгийн Засаг даргын 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/157 тоот захирамжийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1. Мал амьтны сэг зэмээс хүн малын халдварт өвчин тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор сэг зэмийг цуглуулж устгах, орчны халдваргүйтгэх ажлыг 2026 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс 2026 оны 05 дугаар 15-ны өдрийг хүртэл хугацаанд зохион байгуулсугай.


2. Ажлын хэсгийг 1-р хавсралтаар баталсугай .

3. Мал амьтны сэг зэмийг устгал, орчны халдваргүйтгэлийг мал амьтны эрүүл мэндийн тухай хууль болон холбогдох журам зааврын дагуу малчид, иргэдийн оролцоотой зохион байгуулж, шаардагдах халдваргүйтгэлийн бодис, хөдөлмөр хамгааллын хувцсаар хангаж ажиллахыг Мал Эмнэлгийн Хяналтын Улсын Байцаагч (Э.Оюунтунгалаг)-т, ажлын гүйцэтгэлийн тайланг холбогдох дээд газарт хүргүүлж ажиллахыг Мал эмнэлгийн Тархвар зүйч (Б.Баярцэцэг)-д үүрэг болгосугай.

4. Сэг зэм устгах, халдваргүйжүүлэх ажилд шаардагдах унаа тээврийн хэрэгслээр хангаж ажиллахыг ОНӨААТҮГазрын дарга Л.Баярхүүд, Мал амьтны сэг зэмийг булж устгахад хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны улсын хяналтын байцаагч (Б.Гүрсүрэн) нарт даалгасугай.

5. Үхсэн мал, амьтны хүүр, сэг зэм байсан хашаа хороо, өтөг бууц, сэг зэмийг ачиж цуглуулсан тээврийн хэрэгслийг зориулалтын эмийн бодисоор халдваргүйжүүлэхийг мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.ЛХАГВАДОРЖ